



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/256

Хэрлэн сум

Эмч нарыг шагнахад
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.7, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан хүн амын эрүүл мэндийг сахин хамгаалах үйлсэд үр бүтээлтэй ажилласан эмч нарыг “Аймгийн Засаг даргын нэрэмжит” шагналаар шагнахад 1,340,000 (нэг сая гурван зуун дөчин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3. Шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2023 оны
04 дугаар сарын 25-ны өдрийн
А/25.6 дугаар захирамжийн хавсралт

ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

| № | Шагналын сан, өргөмжлөл | Тоо, ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|----------|---------------------------|-------------|----------------|----------|
| 1 | Ц.Ариунтунгалаг | 1 | 500,000 | 500,000 |
| 2 | Н.Батзаяа | 4 | 500,000 | 500,000 |
| 3 | Өргөмжлөл, дурсгалын зүйл | 2 | 150,000 | 300,000 |
| 4 | Батламж | 1 | 20,000 | 40,000 |
| Нийт дүн | | | 1,340,000 | |